



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны III байр  
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09  
<http://www.ub.inspection.gov.mn>  
E-mail: [ub\\_info@inspection.gov.mn](mailto:ub_info@inspection.gov.mn)

2017. 02. 15. № 02-07-107/18.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аюулгүй байдлыг хангуулах тухай

Сар шинийн баяр болох гэж байгаатай холбогдуулан нийслэл хотын авто зам, замын байгууламжийн ашиглагч болон засвар үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад авто тээврийн хэрэгслийн дугаарын хязгаарлалт үйлчилэхгүй өдрүүдэд авто зам, замын байгууламжийн аюулгүй байдлыг хангуулах болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсээс дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Цагаан сарын баярыг тохиолдуулан “Авто замын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1.1 дэх /авто тээврийн хэрэгсэл саадгүй, аюул осолгүй зорчиход авто зам, замын байгууламжийг бэлэн байлгах заалт/-ын дагуу авто зам, явган хүний замын цас мөсийг цэвэрлэж хальтиргаа гулгаанаас хамгаалан иргэдэд ая тухтай аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэн хэрэгжүүлэх.

2. Авто зам, замын байгууламж, гэрлэн дохионы бүрэн бүтэн байдлыг “Авто замын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1.1 дэх /авто тээврийн хэрэгсэл саадгүй, аюул осолгүй зорчиход авто зам, замын байгууламжийг бэлэн байлгах/ заалтын хүрээнд хангуулах

3. Цаг агаарын болзошгүй аюултай нөхцөл байдал үүсэх, зам даваа хаагдах үед аваарын нөхцөлд ажиллах техник тоног төхөөрөмж, хүн хүчийг хувиарлан бэлэн байдалд ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байхыг тус тус зөвлөж байна.

Хувийг: Улаанбаатар зам засвар арчлалтын газарт хүргүүлэв.

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ



003168000510